


## 17

## Агааржуулалт



Бүх барилга агаар оруулж, гаргах агааржуулалтын системтэй байдаг. Гэвч олон үйлдвэр агаар дахь хортой химийн бодис, тоосыг хөдөлгөдөггүй, үйлдвэрийн агааржуулалтгүй, эсхүл агааржуулалтын тааруухан системтэй байдаг нь ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг.

Үйлдвэрийн эзэд таныг болон таны амьсгалах агаарыг аюулгүй байлгаж хамгаалах үүрэгтэй:

- Үйлдвэрийг бүх ажилчдад хүртээмжтэй цэвэр, шинэ агаартай байлга;
- Аль болох бага химийн бодис хэрэглэх, бодис зайлшгүй хэрэглэх бол аль болох багыг хэрэглэх, химийн бодисын бага хор хөнөөлтэйг нь хэрэглэж ажилчид болон орчин тойрноо хордуулах, өртүүлэх эрсдэлийг багасга;
- Багаж хэрэгсэл, химийн бодис болон ажлын үйл явцад хэрэглэх зүйлсийг аль болох бага уур, тоос гаргах зүйлээр орлуулан соль. (226-235 дугаар хуудсыг үз)

- Химийн бодис, тоос болон дулаан хуримтлагдахаас урьдчилан сэргийлж, үйлдвэрээс гарга;
- Үйлдвэрийг тааламжтай температуртай байлгаж (15-р бүлгийг үз: Халуун ба хүйтэн нөхцөл) ажилчдад уух цэвэр ус, хангалттай амралт өг. (540-р хуудсыг үз)

## Агааржуулалтын систем муу байх нь таныг өвчлүүлнэ

Үйлдвэрийн агааржуулалтын систем сайн ажиллахгүй байх үед химийн бодис, тоос ажилчдын биед орох магадлал нэмэгдэнэ.

Химийн бодис, тоостой агаараар амьсгалж байгаа бол та өөр бусад замаар ч химийн бодист өртөж байж болзошгүй юм. Уух унд болон хоолоор эсвэл ажлын дараа тамхи татсанаар химийн бодис нь таны арьсанд шингэж, бас ходоодонд орж болно. Хэрвээ үйлдвэрээс гарч байгаа агаар бохирдсон бол та магадгүй ажлаа дууссаны дараа ч химийн бодис, тоосонд өртөж байгаа. Химийн бодис хэрхэн таны биед орж хор хохирол учруулдаг талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Химийн бодисын аюул, 8-р бүлгийг үзнэ үү.



Эрүүл мэндийнхээ асуудлуудыг тэмдэглэлийн дэвтэрт тэмдэглэ. Тэмдэглэлийг харьцуулж ижил төстэй болон онцгой содон шинж тэмдгүүдийг ол.

Зарим химийн бодис тэр даруй бие муутгадаг бол зарим нь эрүүл мэндийг доройтуулах шалтгаан болохын тулд их удаг. Химийн бодис, хэт халуун болон агаар дахь тоосонд өртсөн үед илэрдэг шинж тэмдгүүдийг ажигла.

- **Толгой өвдөх, ядрах:** химийн бодисоор амьсгалах нь ихэвчлэн толгой өвдөх эсвэл толгой эргэхэд хүргэдэг боловч энэ нь мөн өөр олон зүйлээс болж болно. Мөн ижил шалтгаанаар байнга ядарч болно.
- **Нүд, хамар ба хоолойн өвчин:** нүд улайх, цочрох, ханиалгах, найтаалгах, хамраас нус гоожих эсвэл хамраас цус гоожих, аль эсвэл ашиглаж байгаа материалын өнгөтэй нус гоожих зэрэг нь та химийн бодис болон тоосоор амьсгалсны шинж тэмдэг юм. Эдгээр шинж тэмдэг нь таныг ажлаа хийхээ болих үед арилж болох ч нэг эсвэл хэд хэдэн химийн бодис таны биед орж, эрүүл мэндийг тань муутгасаар байгаагийн шинж тэмдэг юм.
- **Астма ба уушгины бусад архаг өвчин:** химийн бодис болон тоосоор амьсгалах нь таны уушгийг эдгэршгүй гэмтээж эсвэл хорт хавдар үүсгэх буюу

үхэлд ч хүргэж болно. Зарим өвчнийг эмээр эмчилж болдог. Нийтлэг химийн бодис, материалын талаар 171 ба 221-р хуудаснаас мөн Хавсралт Б-ээс тус тус үзнэ үү.

- **Биений дулаан алдалт:** ажилчид норох, даарах үед биений дулаанаа ихээр алдаж, ялангуяа хангалттай амрах болон ус уух цаг байдаггүйгээс үхэлд хүрч болно. 15-р бүлэг: Халуун ба хүйтэн нөхцөл.
- **Эрүүл мэндийн бусад асуудлууд:** химийн бодисоор амьсгалах нь эрүүл мэндийн олон асуудал буюу бөөр, элэгний гэмтэл, хорт хавдар зэргийг үүсгэж болно. Нярай хүүхэд, хүүхэд, эхийн гэдсэнд байгаа ураг нь химийн бодист илүү хурдан хорддог. Нөхөн үржихүйн эрүүл мэндийг хордуулдаг химийн бодисын талаар 499 дүгээр хуудас, Хавсралт Б-ээс үзнэ үү.

Хэрвээ та гэнэт амьсгалж чадахгүй болох юм уу, гэнэт өвдвөл яаралтай ажлын байраа орхин, цэвэр агаараар амьсгалж болох газарт оч. Анхны тусламжийн талаар 238 дугаар хуудаснаас үзнэ үү.


## Ерөнхий агааржуулалтын систем

Ерөнхий агааржуулалтын систем нь үйлдвэр доторх агаарыг хөдөлгөөнд оруулж, агаар дахь химийн бодисын төвлөрлийг бууруулдаг.

Агааржуулалтын сайн систем нь зарим тоос, халуун агаар болон химийн бодисыг зайлуулж, амьсгалахад аюулгүй цэвэр агаараар сольдог. Агааржуулалтын сайн систем нь ажлын байрны агаарын температур болон чийгшлийг, эрүүл, тав тухтай байдлыг хадгалдаг.

Агааржуулалтын системд байгаа бүх төрлийн сэнсний шүүлтүүрт тогтмол үзлэг шалгалт, цэвэрлэгээ хийснээр систем сайн ажиллаж, үйлдвэрээс гарах агаарыг бохирдуулахаас урьдчилан сэргийлдэг. Энэ нь ойр орчмын хүмүүсийг химийн бодисын бохирдлоос шалтгаалах өвчнөөс хамгаалдаг.

Халаалт, агааржуулалтын систем, бас хөргөх сэнсийг ХАХС гэж хэлдэг бөгөөд энэ нь нарийн төвөгтэй төрлийн буюу электроникийн үйлдвэр дэх агаарын урсгал, температур, бас чийгшлийг илүү сайн хянахад хэрэглэгддэг. (328 дугаар хуудсыг үз)



**Агааржуулалтын систем нь үйлдвэр доторх агаарын урсгалыг нэмэгдүүлдэг. Гэвч үйлдвэрээс гарч байгаа агаар нь шүүгдээгүй бол энэ нь үйлдвэрийн гаднах хүмүүсийг өвчлүүлэх болно.**

## Ерөнхий агааржуулалтын систем яаж ажилладаг вэ

Ерөнхий агааржуулалтын систем нь бохир агаарыг ажлын байрнаас гаргаж, цэвэр агаар оруулж байх ёстой.

Цэвэр агаарын тусламжтайгаар химийн бодисын эзлэх хэмжээ шингэрч түүгээр амьсгалах үед үзүүлэх хор хөнөөл нь арай бага болдог. Агаарыг сэлгэх ажлыг хий! Хуудас 332-оос үйлдвэр дундуураа цэвэр агаар хэрхэн нэвтрүүлэхийг үзнэ үү.

### Цонх ба сэнс

Үйлдвэрийн цонх, хаалгыг онгорхой байлгах нь химийн бодисоос болж хүмүүсийг өвчлүүлэхгүй байхад хангалттай байж чадахгүй юм. Ханын сэнс нь үйлдвэрт цэвэр агаар оруулах эсвэл бохир агаарыг гаргахад хэрэгтэй. Гэвч эдгээр нь бүрэн ажиллагаатай байгааг баталгаажуулахын тулд тогтмол шалгаж, бас цэвэрлэдэг байх хэрэгтэй.

## Сэнс нь агаарыг үйлдвэр дундуур сэлгэдэг

Чиглэсэн, бас таазны сэнс нь үйлдвэрийн агаарыг чиглүүлж, тодорхой ажилтныг сэрүүхэн байлгахад тус болно. Хэрвээ танай үйлдвэрийн сэнс бохир агаарыг чиглүүлж, гаргадаггүй бол энэ нь ердөө л тоос болон химийн бодисыг үйлдвэр дотор хөдөлгөж байна гэсэн үг юм.


Хэрвээ танай үйлдвэр халуун, бас сэнснүүд нь тан руу халуун агаар үлээж байвал халуунаас үүсэх өвчнөөс сэргийлж аль болох их ус уугаарай.

## Хавхлаг болон гаргах сэнс, яндан нь бохир агаарыг гадагшлуулдаг

Дээврийн хавхлаг нь дулаан агаарыг гаргадаг. Эдгээр нь цэвэр агаар татагдаж орох, агаар шинэчлэгдэх үйл явцыг бүрдүүлдэг.

Яндантай сэнс нь зөвхөн ойр орчмын зарим хэсгийн агаарыг сордог учир ерөнхий агааржуулалтын системд тус болохгүй. Хэрэв хангалттай цэвэр агаар гаднаас орж ирэхгүй бол гадагшлагч яндантай хавхлаг нь сайн ажиллахгүй эсвэл огт ажиллахгүй байж болно. Гадагшлагч яндантай сэнс нь хүч муутай бол бохир агаарыг хангалттай хэмжээнд гадагшлуулахгүй.

Дотоод агаар шахагч нь агаарыг ойр орчимдоо шахахдаа эсвэл үйлдвэр рүү оруулахдаа шүүлт хийж байх ёстой ба тэгэхгүй бол бага ч гэсэн химийн бодисын агууламж нь хүмүүсийг өвчлүүлж болно. Хэрвээ ерөнхий агааржуулалтын систем шүүлтүүргүй бол агаар дахь химийн бодис нь эрүүл мэндийн асуудлын шалтгаан болох ба ялангуяа үйлдвэрийн ойролцоо байгаа жирэмсэн эх болон хүүхдүүдийг өвчлүүлж болно. 33-р бүлэг: Үйлдвэрийн хог хаягдал хэсгийг үзнэ үү.



Хэрвээ тэд үүнийг шалгаж, цэвэрлэхгүй бол сайн агааржуулалт болж чадахгүй.

## Агаарын урсгал танд тус болж байна уу эсвэл таныг хохироож байна уу

Мартина нь Мексикийн радио угсрах үйлдвэрт ажилладаг. Тэр хуванцар хэсгүүдийг хүчтэй уусгагчаар цэвэрлэх жижиг цехэд ажилладаг. Түүний ажлын хэсэг урьд нь онгорхой цонхны урд байдаг байсан. Агаар цонхоор орж ирэн түүний хойно байгаа сэнсээр гарах үед тэр химийн бодисын уур болон бага зэрэг цэвэр агаараар амьсгалдаг байв. Мартинагийн толгой өвдөж, бас хамар нь шуухитнах болж өдөр бүр ханиах болов.



Агааржуулалтын талаарх сургалтын дараа Мартина даргаасаа түүний ажлын хэсгийг өрөөний нөгөө талд шилжүүлж өгөхийг хүсэв. Дарга нь түүнд зөвшөөрсөн, учир нь гэвэл тэрбээр суурин сорогч сэнс зэрэг шинэ юм гуйгаагүй юм. Одоо цэвэр агаар цонхоор түүний хойноос орж ирэн химийн бодисын уурыг түүнээс холдуулж байна. Сорогч сэнс нь бүх уурыг түүнээс хол байлгах, байшингаас гаргахаар хангалттай хүчтэй сэнс байв. Мартинад одоо хамаагүй дээр болов.

Завгүй улирал эхлэх үед илүү олон хүн ажилд оров. Одоо Мартина ажлын хэсгээ Селестэтэй хуваалцдаг. Дарга нь Селестэг цонхны урд буюу өмнө нь Мартинагийн ажилладаг байсан хэсэгт байрлуулсан. Хэдий үйлдвэр нь цэвэр агаар оруулах хангалттай боломжтой ч одоо ажиллах хэсгийн агаарын урсгал эрүүл биш юм. Селестэ болон Мартина хоёр аль аль нь химийн бодисоор амьсгалж, энэ нь тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.




## Тусгай зориулалтын ерөнхий агааржуулалтын систем

Халаалт, агааржуулалт, хөргөх сэнс (ХАХС)-ний системийг “цэвэр өрөө” буюу чийгшил болон температурыг яг зөв түвшинд хадгалах ёстой ажлын байранд хэрэглэдэг.

ХАХС систем сайн ажиллахын тулд дараах байдлаар байх хэрэгтэй:

- **Агаарын оролт, гаралтыг тэнцвэржүүлэх.** Хэрвээ агаар оруулах сэнс нь хэт их агаар хүчтэй оруулж ирвэл агаар гаргах хавхлагийн ачаалал ихдэж, бохир агаарыг хангалттай хэмжээнд гадагшлуулж чадахгүйд хүрнэ. Тоос болон химийн бодис нь цэвэр өрөөнд хуримтлагдах болно.
- **Агаарыг цэвэрлэ, бас шүү.** Бохир агаар, их хэмжээний тоос болон химийн бодис нь хамт шахагдан гарч, цэвэрлэгдэж, бас шүүгддэг. Цэвэр өрөөний агаарын бараг 70 хувь нь цэвэрлэгдсэний дараа буцаж өрөөнд шахагддаг. Хэрвээ цэвэрлэгдсэн, шүүгдсэн агаар нь хянагдаж, шинэчлэгдээгүй бол эдгээр нь химийн бодисыг бүгдийг нь шүүгээгүй байж болно.




- **Температур болон чийгшлийг хяна.** Агааржуулагч нь ажлын хэсгийг сэрүүн болгож, уур манангийн эзлэх хувийг багасгаж, хуурай бас цэвэр өрөөнд хэрэглэгдсэн химийн бодисоос цэвэрлэсэн байдаг. Тиймээс температур нь магадгүй хэт хүйтэн болж болно. 15-р бүлэг. Халуун ба хүйтэн нөхцөл хэсгийг үзнэ үү.

## Хэсэгчилсэн агааржуулалтын систем

Тусгайлсан агааржуулалтын систем нь ажил хийж байгаа газарт ойр байх ба ингэснээрээ үүссэн ихэнх химийн бодис, уур, тоос, халуун болон уурыг агаарт орж түүгээр амьсгалахаас нь өмнө нэн даруй зайлуулдаг.

Тусгайлсан агааржуулалтын системийг заримдаа сорогч, яндантай хавхлаг эсвэл тусгай агааржуулалтын систем гэж нэрлэдэг. Тусгайлсан агааржуулалтын систем нь ерөнхий агааржуулалтын системийг орлодоггүй. Энэ хоёр систем нь хоёулаа ажиллаж байж ажилчдыг хамгаалдаг.




Тусгайлсан агааржуулалтын систем нь дараах ажилд хэрэгтэй:

- Тасдах, хөрөөдөх, бас зүлгэх, учир нь эдгээр нь ихээхэн хэмжээний тоос, хог үүсгэдэг. Маш их тоостой ажлын хэсгийг тоос сорогч, нойтон алчуур эсвэл поролоноор тоос тархахаас урьдчилан сэргийлж сайтар цэвэрлэдэг байх хэрэгтэй;
- Наах, гагнах болон хэсэгчилсэн цэвэрлэгээ, учир нь эдгээрт химийн бодис хэрэглэдэг ба энэ нь уур үүсгэдэг;
- Манантуулах, шүрших ажил, учир нь агаарт уушги гэмтээх зүйл цацдаг;

- Химийн бодис болон тоос нь маш амархан гал гаргах эсвэл дэлбэрэлт үүсгэх зүйлс ашигладаг буюу бий болгодог ажил.


Зарим ажлын үеэр эрүүл мэндэд маш аюултай тоос болон химийн бодис агаарт тархахаас урьдчилан сэргийлж тоног төхөөрөмжийг бүрэн тусгаарлах хэрэгтэй байдаг. Засвар үйлчилгээ хийх ажилчид нь тоног төхөөрөмжийг онгойлгох болон засвар үйлчилгээ хийхдээ химийн бодист өртөхөөс сэргийлж болгоомжтой байх ёстой. Тусгаарласан тоног төхөөрөмжийн талаар 230-232 дугаар хуудаснаас үзнэ үү.

## Тусгайлсан агааржуулалтын системийн төрлүүд




**Бүрхүүлтэй сорогчийг** ажиллах хэсгийн дээр эсвэл яг хажууд байрлуулдаг. Хэрвээ бүрхүүл нь ажилд ойр бол энэ нь халуун болон бохир агаарыг илүү их зайлуулдаг. Хэрвээ эдгээр нь хэтэрхий хол байвал зарим уур нь агаарт тархаж түүгээр нь та амьсгалдаг. Сэнс, тэр хавиар алхаж буй ажилтан, онгорхой хаалга, цонх нь агаарын чиглэлийг өөрчилдөг. 332-р хуудас дахь Агаарыг дага дадлага ажлыг хий.

**Тусгайлсан сорох хавхлаг** нь ажиллах хэсэгтэй маш ойр эсвэл багаж хэрэгсэл дээр байдаг. Хавхлаг нь таны хийж байгаа ажлаас салхийг уруудуулах ба тэгснээр агаарыг таны нүүр рүү явуулахгүй байлган сордог.



Тоос болон уур энд сорогдож байна.



**Тусгайлсан сорогч бүхээг** нь ажилчин ажил хоёрын дунд зааг үүсгэж, цаашлаад агааржуулалтын системийг ашиглан бүхээг доторх ихэнх тоос, уурыг зайлуулдаг. Ажилчид өөрсдийгөө хамгаалахын тулд зөв бээлийтэй байх хэрэгтэй. 344-348 дугаар хуудсыг үзнэ үү.

Бүх төрлийн тусгайлсан агааржуулалтын системд тогтмол цэвэрлэгээ, засвар үйлчилгээ хэрэгтэй. Шүүлтүүр, сэнс, мотор, бүслүүр, бас хэмжигчийг тогтмол шалгаж, сольж бай. Шүүлтүүр болон агаарын хоолой нь тоос шороонд бөглөрсөн үед илүү их тоос болон химийн бодис агаарт үлдэж ажилчид түүгээр нь амьсгалах болно. Шүүлтүүр нь цэвэрлэгдэж, аюулгүй янзлагдсан байх ёстой.

Хэрэв тусгай агааржуулалтын систем ажиллахгүй эсвэл таны ажлын хэсэгт бий болсон бүх химийн бодис болон тоосыг гаргахаар хангалттай сайн ажиллахгүй байвал та түүгээр амьсгалах болно. Агааржуулалтын системийг янзлахыг даргаасаа шаард. Энэ хооронд өөрийгөө аюулаас хамгаалахын тулд бээлий, амны хаалт хэрэглэ. (18-р бүлэг. Хувийн хамгаалах хэрэгсэл)

## Хэрхэн

## Агааржуулалтын системээ шалгах


Ажиллах хэсэгт цэвэр агаар орж ирж байгаа, бас бохир агаар гарч байгаа чиглэл, урсгал, хүчийг шалгах хялбар арга нь утааны шалгалт юм. Үүнд олон төрлийн утаа шалгагч байдаг. Зарим нь таны эрүүл мэндэд муу байж болох ба их утаа гаргадаг. Зарим нь шүдэнзнээс бага утаа гаргах буюу аюулгүй байдаг. Утаа шалгагчийг утааны лонх, утааны үзэг, нунтаг цацагч болон утааны шүдэнзээр хийж болдог. (Хэрвээ хоолой утаа мэдрэгчтэй бол энэ шалгалт үр дүнгүй)

Хэрвээ эдгээрийн аль нь ч танд байхгүй бол хангалттай сайн утаа гаргах бусад зүйлийг ашигла. Шатамхай эсвэл тэсрэмтгий химийн бодис, тоос, гал ашиглаж болохгүй. Агаарын хөдөлгөөнийг шалгах өөр нэг арга нь муруйхааргүй модонд даавууны өөдөс бэхлэх ба түүнийгээ сорогчид ойртуулан шалгах юм.

1. Хэд хэдэн хүж, тамхи, навчин тамхи эсвэл багц навч, цаас буюу удаан шатаж их хэмжээний утаа гаргах шарилж зэргийг хэрэглэ. Хэрвээ та шатамхай, тэсрэмтгий химийн бодис эсвэл тийм зүйл үүсгэх ажил хийдэг бол ямар ч шатах зүйл хэрэглэж болохгүй. Түүний оронд агаарт утаа шиг пургих хүүхдийн нунтаг бүхий нарийхан хоолойтой жижиг сав зэргийг хэрэглэ;
2. Ажиллах хэсгийн хамгийн ойрын сорогчийг асаа;
3. Ажилладаг хэсэгтээ зогс эсвэл суу;
4. Утаа гарга. Тэр хаашаа явж байна? Агааржуулагчийг хаах, хүн хажуугаар нь явах тохиолдолд яаж байгааг ажигла;
5. Хэрвээ бүх утаа шууд сорогчид орж байвал энэ нь сайн ажиллаж байна гэсэн үг;
6. Хэрэв таны нүүр рүү, бусад ажиллах хэсэг рүү эсвэл өөр чиглэлд явж байвал буруу байна гэсэн үг юм. Магадгүй хангалттай агаар орж ирэхгүй,

магадгүй таны ойр орчмын хөдөлгөөн утааны чиглэлд нөлөөлж, аль эсвэл сорогч сэнс хангалттай хүчтэй байгааг илтгэж болно. Хамт ажилладаг хүмүүсээрээ бас үүнийг хийлгэ;

**7.** Хэрвээ бүх утаа сорогчид татагдахгүй бол та хамтран ажиллагчидтайгаа энэ асуудлыг шийдэж, янзалж чадах хүн олохыг даргаасаа шаард.



## Дасгал


## Агаарыг дагах

### 1. Үйлдвэрийнхээ агааржуулалтын системийн зураглалыг зурах

Хэрвээ та том үйлдвэрт ажилладаг эсвэл цэвэр өрөөнд ажилладаг бол ажиллах хэсгийнхээ зураглалыг гаргах нь танд хэрэг болно.



• **Агаар хаанаас ирж байна вэ?** Агаар орж ирэх бүх эх үүсвэрийг зур, тэр ч байтугай “хаалга, цонх онгойх үе”-ийг хүртэл. Аль эх үүсвэр нь их эсвэл бага агаар оруулж байна вэ? Гаднаас орж ирж байгаа агаар нь цэвэр байна уу эсвэл үйлдвэрийн нэг хэсгээс орж ирж байна уу?



• **Агаар хаашаа явж, бас үйлдвэр дотор хөдөлж байна уу?** Агаарыг мөшгөх нь их хэцүү. Гэхдээ агаар орж ирснийхээ дараа хаашаа явж байгааг зурахыг хичээ. Агаарыг хөдөлгөж болох сэнснүүдийг харуул. Утаа эсвэл нунтгаар жигд урсгал үүсгэж, дараах аргаар хуудас 332-ын дагуу үйлдвэрийн агаар яаж хөдөлж байгааг харж, тусгайлсан агааржуулалтын системийг шалга.

• **Агаар гаргах хавхлаг эсвэл сорогч нь хаана байна вэ?** Зарим үйлдвэрт цонх болон хаалга нь агаар гаргах цорын ганц зам байж болох юм.

• **Ажлын аль хэсэгт, хаана нь хүмүүс өвчилж байна вэ?** Асуудалтай байгаа хэсэгт агааржуулалт тааруу байж болох юм. Агааржуулалтын систем муу байх нь таныг өвчлүүлнэ - 323 дугаар хуудсыг үз.

## 2. Үйлдвэрийнхээ агааржуулалтын системд хяналт тавих

Засвар үйлчилгээний ажилчдаасаа тусламж хүс. Тэд агааржуулалтын системийн талаар танд хэлж эсвэл зураг авч (танаар зураг авхуулж) чадна. Тэдэнд агааржуулалтын муухан системээс болж эрүүл мэндийн ямар асуудал үүсэж байгаа болон үүнд тэднийг огт буруутгаагүй болохоо ойлгуул.

## 3. Агааржуулалтын системд хэрхэн засвар үйлчилгээ хийдэг болох талаар олж мэдэх

Сэнс, сорогч болон хавхлаг нь бохирдож, бас эвдэрдэг. Түгжирсэн, эвдэрсэн сэнс, хавхлаг, сорогчийг сольж, засаж, үзлэг хийж, сайн агааржуулалтын системийн төлөвлөгөөтэй байх хэрэгтэй.

Хавхлагт орж эсвэл гарч байгаа агаарыг хааж байгаа ямар нэгэн зүйл байна уу?
Хавхлаг хэр тоостой байна вэ?
Та химийн бодис эсвэл тоос үнэртэж эсвэл харж байна уу?
Агаар орох эсвэл гарах хэсгийг үйлдвэрийн гадна талд ямар нэг зүйл хааж байна уу?
Агааржуулалтын систем үргэлж асаалттай байна уу эсвэл заримдаа асаалттай байна уу?
Сэнс болон сорогчид нь хангалттай хүчтэй байна уу?

- Тэдгээрийг цэвэрлэсэн үү? Засвар үйлчилгээний ажилчдаас эдгээрийг хэн хэр ойрхон цэвэрлэдэг болохыг асуу. Тэдэнд магадгүй цэвэрлэсэн эсвэл зассан шүүлтүүр хэрэгтэй байж болох юм. Тэдэнд хамгийн сүүлд хийсэн бүртгэл байна уу? Мөн тэднээс цэвэрлэхдээ юу хэрэглэдэг талаар асуу.

- Хэр ойр ойрхон, хэн шалгадаг вэ?

- Эд анги нь эвдрэхэд хэр хурдан шинэчилдэг вэ?



## Ажлын байранд цэвэр агаартай байх эрх



**ОУХБ-ын Ажлын байрны орчны (агаарын бохирдол, дуу чимээ ба чичиргээ) тухай конвенц (№148)-ын** дагуу ажил олгогч нар дараах үүрэгтэй:

- Агаарын бохирдлыг бууруулах систем суулгах, ажлын байрыг зохион байгуулах;
- Агаарын бохирдлыг бууруулахын тулд ажил хийгдэж буй горимыг өөрчлөх;
- Агаарын бохирдлыг бүхэлд нь багасгах боломжгүй бол ажилчдад тохирсон хувийн хамгаалах хэрэгслээр хангах ажлыг хариуцах;
- Эрүүл мэндийн үзлэгээр ажил нь ажилчдад хортой гэдгийг олж мэдвэл өөр тохиромжтой ажлаар хангах.

**Ажлын байрны орчны тухай конвенц-оор** ажилчид дараах эрхтэй:

- Агаарын бохирдлоос хэрхэн хамгаалах талаар мэдээлэл болон сургалт авах;
- Эрүүл мэндийн үзлэгт орох;
- Ямар нэгэн өс хонзонгоос айхгүйгээр агааржуулалтыг сайжруулах хүсэлт гаргах;
- Засгийн газарт үйл ажиллагаа, бодис, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь агаарын бохирдлын шалтгаан болж байгааг мэдээлэх ба тэд ажил олгогчдыг үүнийг засах, сайжруулах эсвэл солих талаар дэмжиж туслах.

**ОУХБ-ын ажилчдыг хамгаалах эрүүл мэндийн шаардлага (№97)-ын дагуу** ажил олгогч нь дараах зүйлсийг хийх ёстой:

- Ажилчид аюулгүй, бас хангалттай агаартай байх;
- Ажлын байрны агаарын температур болон чийглэг нь тав тухтай хэмжээнд байх;
- Аюултай химийн бодис хэрэглэдэг ажиллах хэсэгт олон дахин шалгалт хийж байх.

НҮБ, ОУХБ болон ажилчдын эрхийг дэмжих талаар бусад олон улсын байгууллагын үүрэг, оролцооны талаар Хавсралт А-д тайлбарласан болно.

## Агааржуулалтын сайн систем нь хүн бүрийн эрүүл мэндийг сайжруулна

Химийн бодис болон тоосгүй агаараар амьсгалснаар ажилчид зөвхөн эрүүл саруул байна гэсэн үг биш юм. Тэдний гэр бүл, нийгэм, мөн түүнчлэн үйлдвэрийн удирдлагын эрүүл байх, сайн сайхан байдал хүртэл үүнээс хамаарна.

Зарим агааржуулалтын системд өөрчлөлт, засвар үйлчилгээ хийхэд маш хялбар байдаг. Харин зарим нь илүү үнэтэй байдаг. Танд ч мөн заавал даргаа оролцуулахгүйгээр агааржуулалтын системээ сайжруулах шинэ санаа төрж болох юм.

## Агааржуулалтын системийн ажилчдын хороог байгуулах

Хамтран ажиллагчдаа урьж, агааржуулалтын асуудалд анхаарч ажиллах баг байгуул. Энэ багт хэн ч орж болно. Учир нь үйлдвэрт байгаа хүн бүр илүү сайн агааржуулалтын системийн ач тусыг хүртэнэ.



**Танай үйлдвэрт агааржуулалтын системийн ямар асуудлууд байгааг үзлэг, шинжилгээ болон зурагжуулах аргаар олж илрүүлэх.** (3-р бүлэг. Ажиллагчдын эрүүл мэндийг сайжруулах ажлыг зохион байгуулах) Цугласан бүх ажилчидтай бүх мэдээллийг хуваалц.

**Агааржуулалтын системийн талаар мэддэг** буюу засвар үйлчилгээний ажилтан, агааржуулалтын систем угсрах ажилтан, эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн болон бусад хүнээс тусламж хүс.

**Хамтран ажиллагч, ахлагч болон даргадаа хандах.** Агааржуулалтын системд тогтмол засвар үйлчилгээ хэрэгтэй. Шинэ агаар сорогч авах нь урагшлах сайн алхам байж болох ч тогтмол шалгаж, цэвэрлэхгүй бол таны эрүүл мэндийг хамгаалахгүй юм. Мониторинг хийх, шалгах, засвар үйлчилгээ хийх, цэвэрлэх бүх л үе шатанд ажилчдын оролцоог хангахыг шахаж, шаард.



Дарга бидэнд mask өгчихөөд "Одоо та нар хамгаалагдсан" гэж хэлсэн. Түүнээс энэ компанийг худалдаж авсан хүнд голдол гаргах хүртэл тэр агааржуулалтын системд ямар нэгэн өөрчлөлт хийхийг эсэргүүцэж байсан.

### **Ажилчид зохион**

**байгуулалтад орж** илүү том өөрчлөлтийг хийж ялалт байгуулахын зэрэгцээ агааржуулалтын системийг сайжруулах арга замуудыг ч бас бодох ёстой. Жишээлбэл, даргаасаа агаар сорогч суулгахыг шаардахын хажуугаар ажлын талбарыг илүү агаарын солилцоо сайтай газарт шилжүүлэх. Ямар өөрчлөлт хийж болох талаар хэлэлцэх үедээ бүх ажилчдын оролцоог хангах.

**Үйлдвэрчний эвлэл, ажилчдын төв, ТББ-ын хүмүүстэй ярилцаж,** бусад хүмүүс агааржуулалтын системийг илүү сайн болгоход ямар ажил зохион байгуулсан талаар мэдэж, тэдний туршлагаас суралц (юу нь болж, юу нь болохгүй байв). Цуглуулсан мэдээллээ дүгнэж, бусдаас тусламж авч, мөн ажлын байрыг яаж сайжруулах талаар зөвлөгөө ав.

**Засгийн газрын албан тушаалтанд хандан** улсынхаа агааржуулалтын системийн тухай хуулийн талаар сурч мэдэж, алийг нь ямар замаар шаардаж болох талаар судалгаа хий. Хэрвээ энэ чиглэлийн хууль тогтоомж сул эсвэл агааржуулалтын системийн зохицуулалтыг компани өөрөө мэддэг бол хуулийн байгууллага болон пүүсээс хэрхэн нөлөөлөх болон хуулийг өөрчлөх талаар тусламж ав. Олон улсын конвенцоос тус болох зүйл олдох эсэхийг үзнэ үү. (Хавсралт А: Зохистой, эрүүл, шударга ажлын төлөөх тэмцэл ба хууль тогтоомж) Эсвэл танай үйлдвэрт хийгдэж байгаа брэндийн "Ёс зүйн дүрэм"-ийг үз.

**Орон нутгийнхаа агаарын бохирдлын эсрэг ажиллаж** байгаа олон нийтийн нийгэмлэгтэй ярилц. Үйлдвэрээс сорогдож байгаа бохирдсон агаар нь үйлдвэрийн доторх болон гаднах бүх хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлж

болно. Үйлдвэрийн агааржуулалтын системийн зохицуулалт болон хяналтыг сайжруулахыг засгийн газраас шаардах, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, багасгах үйл ажиллагаанд нэгд.


### Илүү сэрүүхэн үйлдвэр

Эль Салвадорт байдаг Оэшн Скай үйлдвэр нь өдөр дунд маш их халдаг. Менежерүүд нь “хулгайг багасгана” гээд үйлдвэрийн хаалга цонхыг түгждэг тул цэвэр агаар огт орж ирдэггүй юм. Бүр ажилчдынх нь хөлс тэдний хийж байгаа Пума болон Адидасын хувцас руу гоождог байв.

Ажилчид хамтдаа өөрчлөх шаардлагатай зүйлсийн талаар ярьж эхлэхэд тэнд маш их зүйл байгааг ойлгосон юм. Хэд хэдэн үйлдвэрчний эвлэл, Мухерес Трансформандогийн эмэгтэйчүүдийн бүлэг болон бусад олон улсын байгууллагын тусламжтайгаар дээрх зүйлстэй нэг зэрэг тэмцэхээр шийдсэн байна.

Ажилчид агааржуулалтын системээ сайжруулах төлөвлөгөө гаргахын тулд материал цуглуулж, судалж, засгийн газар болон экспертүүдийг оролцуулсан юм. Засгийн газрын төлөөлөл ирж үйлдвэрийн температурыг шалгах үед тэд үйлдвэрт ямар халуун байгааг хараад очирдсон. Албаны хүмүүс үйлдвэрийн даргад хаалга цонхоо онгойлгож, агаар сорогч сэнс болон үйлдвэрийн эргэн тойронд сэрүүцүүлэгч сэнс байрлуул гэж хэлэв. Одоогийн байдлаар үйлдвэрчний эвлэл болон ТББ-тай нэгдсэн хүчин чармайлтаар брэндүүдийн үйлдвэрт өгсөн гэрээг анхааралдаа авчээ. Өөрчлөлт хийхийг захирлаас нь бас шаардсан юм.

Хэдэн сарын дараа бас нэг байгууллага хийсэн өөрчлөлтийг шалгахар ирлээ. Бүх цонх онгорхой ч агаарын урсгал муу хэвээр байв.



Тавиурууд үйлдвэрт агаар орох хэсгийг хааж байв. Тиймээс түүнийг илүү тохиромжтой байрлал руу шилжүүлсэн юм.

Одоо ажилчид өмнөх шигээ их хөлрөхгүй болсон ч маш олон хүн харшил болон амьсгалын асуудалтай байлаа. Тэд цаашид үйлдвэрийн тоног төхөөрөмжийн үүсгэсэн тоосыг хэрхэн соруулуулж байх талаар хэлэлцэж байна.